



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Хурал дахь Намын бүлгийн Ажлын албаны  
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, Сангийн сайдын 2014 оны 122 дугаар тушаал, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 09 дүгээр тогтоолын 3 дугаар бүлгийн 3.25 дахь заалт, 2013 оны 02 дугаар тогтоолын 3 дугаар бүлгийн 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь Намын бүлгүүдийн Ажлын албаны бүтэц, орон тоог хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Бүтэц, орон тооны өөрчлөлтөд орсон ажилтнуудад холбогдох хуулийн дагуу тэтгэмж олгохыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.
3. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь Намын бүлгүүдийн Ажлын албаны бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан Намын бүлгүүдийн Ажлын албаны ажилтнуудыг тус тусын намын байрандаа байршуулан ажиллуулахыг Хурал дахь Намын бүлгүүдийн Ажлын албаны дарга нарт хариуцуулсугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 17 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100077

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 сарын  
10-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь Намын бүлгийн  
Ажлын албаны орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл

Д/д	Албан тушаал	Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэглэл	Ажлын байрны орон тоо
1.	Ажлын албаны дарга	УТ	ТЗ-7-ийн жишгээр	1
2.	Ажилтан	УТ	ТЗ-4-ийн жишгээр	1